

ЛУВСАННОРОВШАРАВЫН “САЙН ГАЛАВЫН МЯНГАН
БУРХАНЫ МӨРГӨЛ ТАХИЛЫН ЕРӨӨЛ” ХЭМЭЭХ
ЗОХИОЛЫН УРАН САЙХНЫ ОНЦЛОГ

Д.Бүрнээ*

“Сайн галавын мянган бурханы мөргөл тахилын ерөөл лүгээ сэлт буяны ногоог дэлгэрүүлэх рашааны их хур хэмээх оршив” \bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myu gu ‘phel bar byed pa’i bdud rtsi’i char chen zhes bya ba bzhugs\ зохиол нь Лувсанноровшаравын сүмбүмийн Ка буюу нэгдүгээр ботид буй. Нийт 41 хуудас. Төгсгөлийн үгийг орчуулбал “Сайн галавын мянган бурханы мөргөл тахилын ерөөл лүгээ сэлт буяны ногоог дэлгэрүүлэх рашааны их хур хэмээх энэ нь мянган бурханы хөргийг шинээр байгуулах ба аравнай үйлдэх үед сэтгэл номхон хийгээд эрхтэнийг сайтар амарлиулсан хуурмаг үгүй сүсэг лүгээ төгөлдөр тойн Доржжалцан бээр бурхан тэдгээрийн алдар нэр бүхий мөргөл ерөөл лүгээ сэлт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсан ба өөрөө ч багш тэдгээрийг дээдлэн сүсэглэж хичээнгүйлэн дурдсанд мянган бурханы нэр алдарыг Сайн галавын судраас зарлигласан ёсоор ерөөл нүгүүдийг дээд Алтангэрэлийн судраас зарлигласан ёсоор мөргөл тахилын үе гишүүн лүгээ сэлт бээр завсарыг барилдуулж, дээд лам багш нарын зарлигийн ачаар сайтар амьдрах шагжагийн тойн Сумадиманипражня, бус нэрээр дээд Манзуширийн зарлигийн эшээр Чин сүжигт номун ханд дуудагдах хэмээх бээр эрх баялиг хэмээх улаагчин үхэр жилийн билгийн есөн сарын, сарын хуучийн хоёрдугаар сайн огторгуйгаас буусан дүйчэнд дээд Манзуширийн эш зарлигаар Билиг дэлгэрэх сүм хэмээн алдаршсан хийдэд найруулав, бичээч нь бигшү Вагиндрадармадала болой. Үгээр ялгуусны шашин дэлгэрч өнөд орших ба хамаг амьтан туулсан бурханы хутгийг үгэр олох болтугай” гэжээ¹.

Төгсгөлийн үгд дурдагдаж буй Сумадиманипражня бол Лувсанноровшарав хэмээх нэрийн санскрит хөрвүүлэг болно. Лувсанноровшарав тус зохиолыг сүсэгт тойн Доржжалцангийн хүсэлтээр, “Сайн галавын судар”, “Алтангэрэл” тэргүүтэн судрыг ашиглаж улаагчин үхэр жил буюу 1757 онд Билиг дэлгэрэх хэмээх сүмд бурхан багшийн дүйчэн өдрийг тохиолдуулан бичжээ.

Бүтцийн хувьд тус зохиол гурван хэсэгтэй. Нэгдүгээр *Барилдлага* \sbyor ba\ хэмээх хэсэг *Сүсгийг*

* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

¹ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myu gu ‘phel bar byed pa’i bdud rtsi’i char chen zhes bya ba bzhugs, 406-41a тал.

Д. Бүрнээ

үүсгэхийн тус эрдэм, Эд агуурсыг бэлтгэх гэсэн хоёр хэсэгтэй. Бодот шүтээн \dngos gzhi\ гэсэн хоёрдугаар хэсэг Авралын сэтгэл үүсгэх, Цаглаш үгүй дөрвийг бясалгах, Орон шүтээнийг адистидлах, Урин залахын түүх ба шүлэг, Тахил мөргөл тэргүүтэн долоон үе гишүүнийг өргөх ёс гэсэн дөрвөн хэсэгтэй. Зохиолын гуравдугаар хэсэгт төгсгөлийн шүлэг бичжээ.

Уг зохиолоо бичихдээ Лувсанноровшарав олон уран яруу шүлэг, адилтгал зүйрлэл, үлгэр домгийг ашиглажээ. Тахилын шүлгээ бичихдээ зохист аялгууны утгын чимгийн дотроос дүрстийн чимгийг хэрэглэсэн байна. Тухайлбал:

*Цог ний рин чэн на цог лай дүв би
Лун дог ён дан ван рим жи зэй шин
Түв дан лин ши үй на он то ва
Бал дан ла ма ри ван жал бор дүд*

Эрхэн хоёр чуулганы элдэв эрдэнээс бүтсэн
Эш онолын эрдэмийн үе зэрэгээр чимсэн
Эрхт чадагчийн шашны дөрвөн тивийн дунд сүндэрлэсэн
Эх болсон цог төгөлдөр уулын хаанд сөгдмүй²

Энэ шүлэгт бурхан багшийг Сүмбэр уултай зүйрлэсэн байх бөгөөд бурхан багшийн айлдах хоёр чуулган буюу буяны чуулган болон билгийн чуулганыг дөрвөн зүйлийн эрдэнээс бүтсэн Сүмбэр уулын дөрвөн талтай, эш онолын эрдэмийг нь Сүмбэрийн сүрлэг их яндар буюу тавцантай, бурханы шашныг Сүмбэрийн дөрвөн талд сүндэрлэх дөрвөн тивтэй тус тус зүйрлэхдээ илт өгүүлэх нэрийг хэрэглэжээ. Тухайлбал Сүмбэр уулын олон арван илт өгүүлэх нэр буюу ёгт нэрийн дотроос уулсын эрхт хаан \ri dbang rgyal po\ -ыг сонгож, улмаар бурхан багшийг орчлон ертөнцийн хамгийн сүрлэг гайхамшигт үзэгдэл, сүр жавхлангийн бэлгэ тэмдэг болсон тал бүр нь эрдэнээс бүтсэн, дөрвөн тивийн дунд сүндэрлэн орших Сүмбэр уултай жишсэн нь бурхан багшийн айлдвар сургаал, эрдэм билгийг тодотгосон хэрэг ажээ. Ингэхдээ мөр бүрийг есөн үеэр тэгшлэн шүлэглэсэн байна.

Хамаг амьтныг мунхагийн харанхуйгаас аварч, ариун цагаан сургаалаараа ариусган гэгээрүүлэх багшид бие, хэл, сэтгэлийн үүднээс тахил өргөж залбирах учиртай хэмээн шүлэглэсэн нь:

*Dus gsum phyogs bcur bzhugs pa'i bla ma
Rin chen mchog gsum phyag 'os thams cad la
Dad cing mos pa bstod dbyangs rgya mtshor bcas
Zhing rngul mnyam pa'i lus sprul phyag tshal lo³*

Гурван цаг арван зүгт орших дээд лам хийгээд
Гурван эрдэнэ мөргөх зохистой хотол бүхэн
Магтаалын далай магад болсон багшид сөгдмүй

² bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myu gu 'phel bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba bzhugs, 1 а тал.

³ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myu gu 'phel bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba bzhugs, 8 а тал.

Д. Бүрнээ

Мандах орны тоосон сацуу хувилгаан бүхнээ мөргөмүй хэмээн шүлгэлсэн бол Бурхан багшийн зарлигийн сүр хүчийг тэнгэрийн их хэнгэрэг, арслангийн сүрлэг дуутай зүйрлэн бичсэн нь:

*Lha yi rnga bo che ltar rnam kun tu
Rnam par rtog med legs bshad seng ge 'i sgra
Yan la drug bcus bryan pa legs sgrogs pa 'i
Sangs rgyas dbyangs snyan gsung la pyag tshal lo⁴*

Тэнгэрийн их хэнгэрэг мэт хотол олноо
Тийн атхаг үгүй сайн номлолын арслангийн дуун мэт
Төгс утгат жаран гишүүнээр сайтар чимсэн эгшиг яруу
Туулсан бурханы хоёр үгүй зарлигт сөгдөн мөргөмүй

Ийм уран яруу шүлгээс гадна энэ зохиолын дотор сонин домог бас оржээ. Тухайлбал сайн цагийн мянган бурханыг урин залах тухай өгүүлсэн *Урин залахын түүх ба шүлэг* хэмээх хэсэгт бурханы шашны уран зохиолд тааралддаг Сайн Магадагийн домгийг өгүүлнэ. Энэ домог “Субашидийн” төвд болон монгол тайлбарт бий. Төвд тайлбар “Сайн номлол эрдэнийн сан хэмээхийн сайтар тайлбар хэрэг бүхэн гарах хэмээх оршив”⁵ хэмээх нэртэй бөгөөд тус тайлбарыг төвдийн эрдэмтэн тойн Ринченбал хийсэн бол “Сайн номлолт эрдэнийн сан Субашидийн тайлбар чандманийн түлхүүр” хэмээх монгол тайлбарыг их бичгийн хүн цахар гэвш Лувсанчүлтэм зохиожээ. Тойн Ринченбал, Цахар гэвш Лувсанчүлтэм, Лувсанноровшарав нарын зохиол дахи Сайн Магадагийн домгийг харьцуулан үзвэл агуулгын хувьд төстэй, харин зохиомжийн хувьд ялгаатай. Тойн Ринченбалын тайлбарт өгүүлсэн домгийг төвд хэлнээс орчуулбал:

“Эрт цагт Шравастийн хотлыг баясгах хүрээнээ Итгэл үгүйд идээн өглөгтийн охин Сайн Магада хэмээх байжээ. Өмнө зүгийн нэгэн орны гэрийн эзэн олон удаа гуйж элч илгээхээд эс өгөв. Улмаар бурхан багшид энэ тухай айлтгахад өгөгтүн хэмээсэн учир охиныг өгчээ. Магада охин айлын бэр болоод ихэд уйтгарлан суухад гэрийн хүмүүс юунд уйтгарлах болсоныг нь асуухад “Танайд тариалан байхгүй юм” гэжээ. Гэрийнхэн нь “Тариалан бий. Түүгээр зорчин зугаалж болно” гэхэд Магада охин “Буяны тариаланг хэлсэн билээ” гэв. “Энэ юу гэсэн үг вэ, тэр чинь хаана байх буй” гэхэд Магада охин “Бурхан багшийг хэлэв” гэхэд олноор зөвшилдөж, хүүхний урмыг сэргээхийн тулд бурхан багшийг урихаар болж энэ тухай охинд хэлэхэд “Багшийг урих эд зүйлийг бэлтгэгтүн” гэжээ. Эр нөхөр нь “Одоо бэлдвэл эртдэх биш үү, нааш ирэхэд нэг сарын хугацаа бий гэхэд “Хугацаа хамааралгүй бэлтгэгтүн” гэжээ. Ингээд бэлтгэсний хойно Магада охин байшингийнхаа дээвэр дээр гарч арц хүж асааж залбиран мөргөхийг Шравастид балгасны хамаг хувраг нар сонсоод бурхан багш Анандад зарлиг болруун “Рид хувилгаан төгс аяга тахимлигууд одогтун, бус нугууд балгастаа үлдэгтүн” гэжээ. Ийнхүү явах болоход зарим нь заан хөлгөлж, зарим нь үүл, зарим нь Малаяа уулыг хөлгөлөн ажирчээ. Тэдний ирж явааг олноор харж машид биширсэн бөгөөд Магада охиноос хамгийн эхэнд явааг “Танай багш мөн үү” хэмээн асуухад “Биш ээ, бурхан багшийн билигт шавь Шарийбуу байна” гэв. Түүнчлэн

⁴ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myr gu 'phel bar byed pa 'i bdud rtsi 'i char chen zhes bya ba bzhugs, 8 б тал.

⁵ Legs par bshad pa rin po che 'i gter gyi rnam par bshad pa dgos don kun 'byung zhes bya ba bzhugs so.

Д. Бүрнээ

бусдыг ээлж дараагаар хэн хэн болохыг тодорхой хэлэв. Хамгийн сүүлд бурхан багш заларчээ. Түүний доод талд амармагийн орны тэнгэр, дээд талд нь дүрстийн орны тэнгэр, баруун зүүн талд нь бодьсатва нарын тоо томшгүй чуулган заларч өргөн хүндлэх ажгуу. Үүнийг харсан охины хадмууд “Одоо энэ танай багш уу” гэхэд “Манай багш энэ мөн” гэж хариулахад бүгд гайхан биширчээ. Бурхан багш тэдэнд сургаал ном айлдахад сонссон бүхэн номд дуршив” гэжээ.

Лувсанноровшаравын зохиол дахь Сайн Магадагийн домгийг төвд хэлнээс орчуулбал “Эрт цагт Сайн Магада бурханыг урин залахын тулд байшингийнхаа оройд гарч бурханы суух зүгт мөргөж, бурханы эрдмийг дурсан санав. Элдэв цэцэг, хүж, анхилуун үнэртэн үнэртүүлж, алтан хумхнаас ус өргөж “Ялж төгс нөгчсөн их нигүүлсэхүй лүгээ төгөлдөр бөлгөө. Би гөрөөс лүгээ адил болсон бөгөөд хязгаар орноо орших буюу. Чухаг дээд лүгээ хагацсаны учир даган барин зохиож, аяга тахимлиг хувраг нар лугаа энэ орноо ажран соёрх” гэв. Бас ийн хэмээв “Шагшаабад, билиг машид ариун, сүсэг төгөлдөр шарваг нар бээр итгэл үгүй бологсдын хэргийг бүтээж, энэрэн нигүүлсэж ажран соёрх” хэмээн залбирчээ. Өргөсөн тэр ус нь Ялж төгс нөгчсөний өмнө хөх биндэрьяан мод болж, тэр модны цэцэг нь Ялж төгс нөгчсөний дээрхи огторгуйд давхарлиг байшин мэт сүндэрлэж, хүж, цэцэгс үүл давхцах мэт оршив. Тэндээс Ананд багшид “Энэ заллага хаанаас ирэв” гэхэд багш бээр “Ананд аа, зуун жаран гурван бээрийн чанад газраа Бурмын модон дэлгэрэх хэмээх балгас буй. Тэндээс ирэв” гэв. Ананд “Тэр балгасыг тэрсүүд нар барих тул рид хувилгаанаар явах хэрэгтэй” гээд хувраг нарт тэмдэгийн модыг түгээгтүн гэв. Дараа өдөр нь эртлэн босоцгоов. Рид хувилгаан төгс аяга тахимлиг нар тэргүүлэн одов. Хамгийг мэдэгч Гаудинья бээр морин тэрэг хөлгөлөн цахилгааныг хувилгаж хур оруулан залрахад Сайн Магадагийн нөхөр “Энэ чиний багш уу” гэхэд “Энэ бүхнийг мэдэгч Гаудинья. Ялж төгс нөгчсөн номын хүрдийг анх эргүүлэхэд анх түрүүн би үгүйг илт болгосон учир эхэнд ирж буй” гэв. Маха Гашиб бээр хадат ууланд элдэв зүйл мод ургуулах хувилгааныг үзүүлэн залрав. Шаарийбуу бээр арслант тэргийг хувилгав. Могалын хүү бээр зааны хааныг хувилгав. Магаг бээр тэргэний булын хэмжээтэй алтан лянхуаг хувилгав. Ганбо бээр гардит тэргийг хувилгав. Датүл бээр явдал мөрийг амарлиулав. Нэвархор бээр алтан дал модны шугуйг, Гадаянагийн хүү бээр биндэрьяан харшийг, Сүйбочэ бээр зааны тэргийг, Срунвангийн хүү бээр галууны тэргийг, аяга тахимлиг Нажан бээр шугуйд зорчин явах, суух тэргүүтэн дүр байдлыг огторгуйд үзүүлэв. Дараа нь Дажанзин бээр хүрдийг эргүүлэх дүрийг үзүүлэхэд гэрийн эзэн Магадагаас “Таны багш мөн үү” гэж асуув. Сайн Магада “Энэ бол Ялж төгс нөгчсөн бурханы агь, сургаалын дээдийг барьсан тэр бээр долоон зүйл эрдэнэ төгсөж, мянган хөвгүүнээр хүрээлүүлэн айсуу.

Гариг оддын эрхэн чуулганаар хүрээлүүлсэн саран мэт
Гол мөрөн мянгаар цутгаж хотлыг дүүргэх далай мэт
Аюул, өвчин эмгэг зовлонгоос гэтэлгэх их төрөлхтөн мэт
Гөрөөсний дунд орших арслан мэт
Шувуудын дунд гарьд мэт, хотлыг гийгүүлэх наран ба
Дөрвөн тивийг эрхшээх хүрдэт хаан адил залармуй” гэв.

Түүнчлэн зарим нь галыг бадрааж, зарим нь хур буулган, зарим нь огторгуйд хэвтэн, зарим нь огторгуйн төв-д оршин, зарим нь элдэв рид хувилгаан үзүүлэв. Тэр мэт бурханы шавь нар заларсан бөгөөд Ялж төгс нөгчсөн бээр Замбутив даяарыг алтан шаргал гэрлээр гийгүүлэн

Д. Бүрнээ

ажрахад тэрхүү гэрэл Шравасти балгаснаас эхлээд Бурмын модон дэлгэрэх орон хүртэл түгэн сацарч хотол олон гайхан сонирхов. Ялж төгс нөгчсөн бурхан огторгуйд ажрахад хойно нь Очирваань, дээр нь ариун орны тэнгэр нар, доор нь амармагийн тэнгэр нар, зүүнээ Хурмаст, баруунаа Эсэр, түүнчлэн таван шанхат арслан, гандарва нар биваа хуур, лимбэ, хэнгэрэг тэргүүтэн зэмсэг барьж, элдэв яруу дуун дуурсган, цэцэг хүж, элдэв үнэртэн цацна. Тэр завсар ялж төгс нөгчсөн далан долоон мянган амьтанд үнэний номыг айлдаж, Бурмын модон дэлгэрэх хийдэд ажрав. Тэр балгаст арван найман үүд байх бөгөөд тэдгээр үүд бүрт арван найман бурханыг хувилган, үүд бүрт бурхан үзэгдэхээр зохиож, түүний хойно Сайн Магадагийн гэрт ажрав. Тийнхүү Сайн Магадагийн намтар мэт гартаа цэцэг хийгээд хүж барьж, сайн галвын мянган бурхан бээр тэргүүлэн арван зүгийн ялгуусны хөвгүүн лүгээ сэлт бүгд огторгуйд шувуу нисэх мэт рид хувилгаанаар ажрах тэдгээрийг урин залах” хэрэгтэй гэжээ.

Төвд, монгол зохиогчдын бичсэн Сайн Магадагийн домгийг хооронд нь харьцуулбал агуулгын хувьд төстэй, өөрөөр хэлбэл Сайн Магада бурханыг урин залсан, бурхан залрахад тэнгэр бурхад рид хувилгаан үзүүлж, улмаар Сайн Магадагийн нөхөр болон хадмын талын хүмүүс гайхан биширч, бурханы зарлигийг сонссон хэмээсэн утгатай. Харин үйл явдлын хувьд зарим зохиолд байх үйл явдал нөгөөд байхгүй. Тухайлбал Лувсанноровшарав бээр Магада охин бурханыг урин залах болсоныг “чухаг дээдээс хагацаж” “алс хязгаар орноо оршсон” учир бурханы ном сургаалыг сонсохыг хүссэн, мөн “итгэл үгүй бологсдын хэргийг бүтээх”-ийг зорьсон хэмээн тодорхой хоёр шалтгааныг дурдсан бол бусад зохиолд нэг шалтгааныг л дурджээ. Мөн Магадагийн хадмууд өөр шашин шүтдэг тухай төвд эрдэмтний зохиолд дурдаагүй бол Лувсанноровшарав, Цахар гэвш нарын зохиолд Сайн Магада охины хадмын нутагт тэрсүүдийн ном буюу буддын бус шашин дэлгэрсэн тухай өгүүлжээ. Лувсанноровшаравын бичсэн домог тойн Ринчэнбалынхаас дэлгэрэнгүй, уран сайхны хувьд онцлог, Цахар гэвшийн зохиолоос уран дүрслэл, адилтгал зүйрлэл илүү олон орсоны хувьд өвөрмөц. Тухайлбал Магада харийн нутагт суугаа дүр байдлыг “хязгаар газраа орших гөрөөс лүгээ адил”, бурхан багш бээр олон шавь нараараа хүрээлүүлэн заларч буй байдлыг:

Гариг оддын эрхэн чуулганаар хүрээлүүлсэн саран мэт
Гол мөрөн мянгаар цутгаж хотлыг дүүргэх далай мэт
Аюул, өвчин эмгэг зовлонгоос гэтэлгэх их төрөлхтөн мэт
Гөрөөсний дунд орших арслан мэт
Шувуудын дунд гарьд мэт, хотлыг гийгүүлэх наран ба
Дөрвөн тивийг эрхшээх хүрдэт хаан адил
Сайн номд мянган нүдэн төгөлдөр номыг тэтгэгч мэт хэмээн бичжээ.

Ийнхүү нэрт эрдэмтэн Алшаагийн Агваандандар бээр “Хайви хажан” /мо: Амны чимэг/ хэмээх зохиолдоо “үсэг ариун боловч зохист аялгуу эс төгсвөөс үзэсгэлэнт эхнэр нүцгэн гүйх мэт. Илт өгүүлэхүй шинэ хуучин дохиогоор эс чимвээс балгадын үг холилдох тул мэргэд орхивоос зохистой” хэмээн бичсэнчлэн Лувсанноровшарав бээр зохист аялгуу, илт өгүүлэхүй ухааны орныг сайтар судалж, уран дүрслэл, адилтгал зүйрлэл тэргүүтнийг чадамгай хэрэглэн энэхүү зохиолоо бичжээ.

Abstract

Luvsannorovsharav was one of the famous Mongolian authors who wrote their works in Tibetan. His work entitled “bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi myu gu ‘phel bar byed pa’i bdud rtsi’i char chen zhes bya ba bzhugs” is included in the first volume of his work. As mentioned in the colophon of this work, it was written in the year of female ox or in 1757 year in the monastery of Bilig Delgerekh. The main feature of this work is that it has a lot of metaphors and epithets. Also one interesting legend is included in this work. This legend’s name is Story of Good Magadha, which was cited many times by Tibetan and Mongolian authors. The comparison of this legend with fragments of the same legend written by other authors shows us the Luvsannorovsharav’s creative attitude to his work.